

Түүх 6 : Нааман жанжин

Библийн эшлэл
[2Хаад 5:14]

Нааман уруудан явж, Бурханы хүний үгийн дагуу Иордан голд долоон удаа булхав.
Түүний бие махбод залуу хүний бие махбод мэт эргэн сэргэж,
тэрээр цэвэршив.

Израильтай хөрш зэргэлдээ Арам улсад Нааман гэдэг нэртэй цэргийн жанжин амьдардаг байв.

Тэрээр улсдаа хүндлэгдсэн нэртэй сайн жанжин байв.

Арамын хаан хүртэл Нааман жанжинд сайн ханддаг байлаа. Гэтэл, Нааман жанжин уяман өвчинтэй болжээ.

Уяман өвчин гэдэг нь хүний биеийг ямар ч мэдрэх мэдрэмжгүй болгодог төдийгүй хар хөлийн хуруунууд бас хөмсөг нь аажим аажмаар салан унасан ч юу ч мэдэрдэггүй аймшигтай өвчин байв.

Нааман жанжны гэрт Израилиас боол болгон авчирсан нэгэн бяцхан охин байдаг байв.

Бяцхан охин Бурханд итгэдэг нэгэн байв. Нэгэн өдөр бяцхан охин жанжны эхнэрт ингэж хэлэв.

“Манай улсад Елиша гэгч эш үзүүлэгч бий. Тэр хүн уяман өвчнийг эдгээж чаддаг.

Елиша, Бурханаас гүйн залбирахад л эдгэрэх болно.” Нааманы эхнэр нөхөртөө сонссон бүхнээ ярьжээ. Ингээд Нааман жанжин Израиль руу явахаар болжээ. Нааман жанжин Елиша эш үзүүлэгчид өгөх бэлгээ маш ихийг бэлдэж зэхээд холын замдаа гарав.

Тэд явсаар Израильд хүрч, Елишагийн гэрт иржээ. Гэтэл Елиша гарч ирсэнгүй. Харин зарц нь Елишагийн үгийг дамжуулав.

“Та Иордан голын усаар долоон удаа биеэ угаавал бие чинь цэвэрхэн болно гэж хэлүүлээ.”

Гэхэд Нааман жанжин маш ихэд уурлав. Гэсэн ч зарц нь түүнд дахин хэлжээ.

“Жанжин минь, Иордан голд долоон удаа биеэ угаах нь амархан ажил шүү дээ.

Энэ хүртэл ирсэн юм чинь хийгээд үзвэл дээр биш гэж үү?”

Нааман жанжин зарцын хэлсэн үгэнд орж Иордан гол уруу явав.

Нэг удаа, хоёр удаа, гурав, дөрөв... зургаа дахь удаагаа усанд булхсан ч бие нь эдгэрсэн шинж байхгүй байлаа.

Тэгээд долоо дахь удаагаа булхтал, гайхалтай зүйл болжээ.

Жанжны бүх бие маш цэвэрхэн болж, бүрэн эдгэрсэн байлаа. Шархалж, идээ бээр гоожиж байсан биеийнх нь бүх газар нь нялх хүүхдийн арьс мэт цав цагаан болон сэргэж, цэвэр болсон байлаа.

Үүнээс хойш Нааман жанжин Бурханд итгэж, Бурханыг хайрладаг хүн болон өөрчлөгджээ.





Үйл ажиллагаа 1.

1. Голын дунд тэмдэглэгдсэн шугамыг хайчлаарай.
2. Уяман өвчин туссан Нааман жанжин болон бүрэн эдгэрсэн Нааман жанжины зургийг хайчилж аваад модон ишэн дээр наагаарай.
3. Өнөөдрийн сурсан түүхийн дагуу, уяман өвчин туссан Нааман жанжиныг голд хийж дээш, доош 7 удаа хөдөлгөсний дараа бүрэн эдгэсэн Нааман жанжинаар солиорой.

Хэрэглэгдэх материал: Цавуу, хайц, модон иш 2 ширхэг



а. Уяман өвчинг эдгээх эмчилгээг Нааман жанжинд зааж өгсөн хүн хэн байсан бэ?

б. Хэн Нааман жанжины бодлыг өөрчилтөл ятгасан бэ?

с. Нааман жанжины өвчин эдгэрсэний дараа тэрээр юу хийсэн бэ?

- Дараах эшлэлийг уншаад, цээжлээрэй. (2Хаад 5:14)

Нааман уруудан явж, Бурханы хүний үгийн дагуу Иордан голд долоон удаа булхав.